

ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ

Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах үйл явц дахь ил тод байдал, олон нийтийн оролцооны хэрэгжилт

Тогтолцоо дүн шинжилгээ судалгааны хүрээлэн НҮТББ

АСУУДЛЫН ТАНИЛЦУУЛГА

Эрдэс баялгийн салбарт Монгол Улсын Үндсэн хуулийн 2019 оны нэмэлт, өөрчлөлтийг хэрэгжүүлэх эрх зүйн шинэчлэлийн үйл явц 2020 оноос хойш өрнөж байна. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам (АҮЭБЯ) 2020-2024 онд Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулж, олон нийтэд танилцуулж байсан боловч Улсын Их Хурал (УИХ)-д өргөн мэдүүлээгүй билээ. Харин 2025 онд хуулийн төслийг нэмэлт, өөрчлөлтийн төсөл болгон боловсруулж, 2026 оны 2 дугаар сард олон нийтэд танилцуулж, 2026 оны 5 сарын 27-ны өдөр УИХ-д өргөн мэдүүлээд байна.

2020-2024 онд явагдсан хуулийн төсөл боловсруулах үйл явцыг харахад Хууль тогтоомжийн тухай хууль (ХТТХ)-д заасан ил

тод байдал, олон нийтийн оролцоог хангах, судалгаа, шинжилгээнд үндэслэх зарчим болон бусад холбогдох нарийвчилсан шаардлагын хэрэгжилт хангалтгүй байв. Тодруулбал, 2021 онд хуулийн төслийг зөвхөн аж ахуйн нэгжийн хүрээнд хэлэлцүүлсэн ба иргэний нийгмийн байгууллагуудтай тэдний хүсэлтийн дагуу нэг удаа уулзалт зохион байгуулсан бол 2022-2023 онд орон нутагт бүсчилсэн хэлэлцүүлэг хийсэн боловч тэр нь хуулийн төслөөр дагнасан хэлэлцүүлэг биш, харин Хариуцлагатай уул уурхайн чуулган, Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын хэлэлцүүлгийн¹ үеэр хуулийн төслийг товч танилцуулж, санал авах байдлаар явагджээ. Харин 2025 болон 2026 оны 2 сард зарим аймгийн төвд хуулийн төслөөр тухайлсан хэлэлцүүлэг хийжээ.

¹ Р.Оюундэлгэр, Б.Ариунзаяа, "Хууль, тогтоомжийн төслийн ил тод байдал ба олон нийтээр хэлэлцүүлэх шаардлагын хэрэгжилт", Нээлттэй нийгэм форум, (2025) <https://forum.mn/product/459176>, 43 дахь тал



Тогтолцоо дүн шинжилгээ судалгааны хүрээлэн нь хууль тогтоомж боловсруулах үйл ажиллагаа, шүүхийн шийдвэрийн чанар үр нөлөөний асуудлаар судалгаа шинжилгээ гүйцэтгэдэг 2023 онд үүсгэн байгуулагдсан төрийн бус байгууллага юм. Төрийн бус байгууллагын зарим үйл ажиллагааг олон нийтэд хууль эрх зүйн мэдлэг түгээх Judilogy төсөл хэлбэрээр хэрэгжүүлж байна.

Судлаачид: М.Маралмаа, Б.Мягмарсүрэн, Р.Оюундэлгэр

Эрдэс баялгийн салбар нь Монгол Улсын эдийн засгийн тулгуур бөгөөд гадаадын шууд хөрөнгө оруулалтын гол салбар тул салбарын эрх зүйн үндсэн эх сурвалж болох Ашигт малтмалын тухай хуулийн аливаа өөрчлөлтийг дотоод, гадаадын хөрөнгө оруулагчид, нөлөөлөлд өртөх талууд буюу уул уурхайн компани, орон нутаг, иргэд, олон нийтэд ил тод мэдээлж, өргөн хүрээнд нээлттэй хэлэлцүүлэх, холбогдох судалгаа, шинжилгээг бүрэн гүйцэд, чанартай хийх замаар тус харилцаанд оролцогч талуудын зөвшилцлийг хангах нь нэн чухал.

Иймд энэхүү дүн шинжилгээний хүрээнд УИХ-аар хэлэлцэгдэж буй Ашигт малтмалын

тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь ХТТХ-д заасан ил тод байдал, олон нийтийн оролцоо, судалгаа, шинжилгээнд үндэслэсэн байх зарчимд нийцэж буй эсэхийг дүгнэлээ. Тодруулбал, ХТТХ-ийн 4 дүгээр зүйлд заасан:

- Ил тод, нээлттэй байх,
- Судалгаа, шинжилгээнд үндэслэсэн байх,
- Олон нийтийн оролцоог хангах зарчим, тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбоотой нарийвчилсан шаардлагуудын хэрэгжилтийг авч үзэв.

ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ БАЙХ ЗАРЧМЫН ХЭРЭГЖИЛТ

Хууль санаачлагч нь хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлсний үндсэн дээр түүнийг өөрчлөх, шинэчлэх шаардлагатай эсэхийг тодорхойлж, хуулийн үзэл баримтлал болон төслийг боловсруулна. Үзэл баримтлал болон хуулийн төсөл нь дээрх судалгааны дүгнэлт, зөвлөмжид тулгуурласан байх ёстой бөгөөд боловсруулсан хуулийн төслийн үр нөлөөг үнэлэн, хэрэгжүүлэхэд гарах зардлыг тооцож, хуулийн төслийг сайжруулна.

Хуулийн төслийг өргөн мэдүүлэхээс өмнө эдгээр тооцоо, судалгааг хуулийн төслийн хамт албан ёсны цахим хуудас болон эрх зүйн мэдээллийн нэгдсэн санд хуульд заасан хугацаагаар байршуулж санал авах ёстой.

Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах үйл явцад ХТТХ-ийн 38 дугаар зүйлийн 38.2-38.4 дэх хэсэгт заасан ил тод, нээлттэй байдлын шаардлагуудыг хэрхэн хангасан байдлыг дор дүгнэв.

Хүснэгт 1. Хуулийн төслийг АҮЭБЯ-ны цахим хуудаст байршуулж, санал авсан байдал

ХТТХ-ийн шаардлага	Хэрэгжилт
Хуулийн төслийг бүрдүүлбэрийн хамт хууль санаачлагчийн албан ёсны цахим хуудаст байршуулах <i>ХТТХ-ийн 38.2 дахь хэсэг</i>	Хуулийн төслийг 2026.01.23-ны өдөр яамны цахим хуудаст байршуулж, олон нийтээс санал авч эхэлжээ. ² АҮЭБЯ-ны цахим хуудас нь олон нийтийн хэлэлцүүлэгт зориулсан тусгай цэсгүй тул дээрх зарлалыг Мэдээ мэдээлэл цэсд байршуулжээ. Энэ хэсэг нь цаг үеийн үйл явдлын мэдээллээр байнга шинэчлэгддэг тул шинэ мэдээ орох бүр хуучин мэдээллийг олж хандахад хүндрэлтэй болдог байна. ³

² Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам, “Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд санал авах тухай” <https://mmhi.gov.mn/%D0%B0%D1%88%D0%B8%D0%B3%D1%82-%D0%BC%D0%B0%D0%BB%D1%82%D0%BC%D0%B0%D0%BB%D1%8B%D0%BD-%D1%82%D1%83%D1%85%D0%B0%D0%B9-%D1%85%D1%83%D1%83%D0%BB-D1%8C%D0%B4-%D0%BD%D1%8D%D0%BC%D1%8D%D0%BB%D1%82/>

³ Р.Оюундэлгэр, Б.Ариунзаяа, “Хууль, тогтоомжийн төслийн ил тод байдал ба олон нийтээр хэлэлцүүлэх шаардлагын хэрэгжилт”, Нээлттэй нийгэм форум, (2025) <https://forum.mn/product/459176>, 62 дахь тал

ХТТХ-ийн шаардлага	Хэрэгжилт
	Иймд АҮЭБЯ цаашдаа өөрийн цахим хуудаст Хууль тогтоомжийн төсөлд санал авах цэсийг тусгайлан гаргах нь зүйтэй.
Санал өгөх хугацааг тодорхой заах <i>ХТТХ-ийн 38.2 дахь хэсэг</i>	Дээрх зард 2026.02.27-ны өдрийн дотор саналаа ирүүлэх талаар заасан.
Худалдаа, хөрөнгө оруулалт, татвар зэрэг бизнесийн орчинд нөлөөлөх хуулийн төслийг 60 хоногоос доошгүй нийтэлж, санал авах <i>ХТТХ-ийн 38.4 дэх хэсэг</i>	АМТХ-ийн төсөлд санал авах зарлал яамны цахим хуудаст хэзээ нийтлэгдсэн нь тодорхойгүй. Харин түүнд хавсаргасан хуулийн төслийн файлыг "АМТХуулийн нэмэлт_өөрчлөлт 2026.01.23" гэж нэрлэснээс харахад 2026 оны 1 сарын 23-ны өдөр нийтэлсэн гэж таамаглав. Дээрхээс харахад хуулийн төсөлд яамны цахим хуудсаар нийт 35 хоногийн хугацаанд санал авчээ.
Хуулийн төслийг бүрэн нийтлэх <i>ХТТХ-ийн 38.4 дэх хэсэг</i>	Хуулийн төсөлд санал авах тухай зарлалд зөвхөн Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон дагалдах хуулийн төслийг хавсаргасан.
Бүрдүүлбэрт хамаарах баримт бичгийг хуулийн төслийн хамт нийтлэх <i>ХТТХ-ийн 38.4 дэх хэсэг, 40.1.2-40.1.3 дахь заалт</i>	Хууль тогтоомжийн бүрдүүлбэрт хамаарах: <ul style="list-style-type: none"> - Үзэл баримтлал, - Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагын тандан, судалгаа, эсхүл хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ, - Үр нөлөөний үнэлгээ, - Зардлын тооцоо, - Дэлгэрэнгүй танилцуулга монгол болон англи хэлээр, - Товч танилцуулга зэрэг баримт бичгийг нийтлээгүй. Хуулийн төслийн дэлгэрэнгүй танилцуулгыг англи хэлээр бэлтгэн нийтлэх нь гадаадын хөрөнгө оруулагчдад хууль тогтоомжийн өөрчлөлтийн талаар мэдээлэл авч, хэлэлцүүлэгт оролцох боломж бүрдүүлэх зорилготой. Гэтэл дэлгэрэнгүй танилцуулгыг огт нийтлээгүй нь дээрх боломжийг хязгаарлажээ. АНУ-ын Төрийн департаментаас жил бүр гаргадаг Хөрөнгө оруулалтын орчны тухай мэдэгдэлд Монгол Улсын эрх зүйн орчны болон бодлогын тодорхойгүй байдал, түүнчлэн хууль боловсруулах үйл ажиллагаанд оролцогч талуудын оролцоог хангадаггүй байдал нь гол анхаарах асуудлуудын нэг ⁴ болохыг дурдсан байдаг.
Олон нийт санал өгөх боломжтой байх <i>ХТТХ-ийн 38.2, 38.4 дэх хэсэг</i>	Хуулийн төсөлд санал авах зард зөвхөн user@mnh.gov.mn мэйл хаягаар буюу бичгээр санал авахаар заасан тул хуулийн үйлчлэлд өртөх орон нутгийн иргэд, малчид саналыг хуульд заасан бусад хэлбэрээр өгөх боломж хязгаарлагдмал байв. Хуулийн төслийн бүрдүүлбэр дутуу, санал авах хугацаа богино зэрэг нь олон нийт бүрэн мэдээлэлд үндэслэн саналаа боловсруулж өгөх боломжийг бууруулжээ.

⁴ U.S. Department of State, "2025 Investment Climate Investments: Mongolia", 2025, <https://www.state.gov/reports/2025-investment-climate-statements/mongolia/>

Хүснэгт 2. Хуулийн төслийг Эрх зүйн мэдээллийн нэгдсэн санд байршуулж, санал авсан байдал

ХТТХ-ийн шаардлага	Хэрэгжилт
Хуулийн төслийг Эрх зүйн мэдээллийн системд байршуулж санал авах <i>ХТТХ-ийн 38.2 дахь хэсэг</i>	Хуулийн төслийг Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем (legalinfo.mn)-ийн Хуулийн төсөлд санал авах цэсд 2026.04.29-ний өдөр нийтэлсэн. 5
Санал өгөх хугацааг тодорхой заах <i>ХТТХ-ийн 38.2 дахь хэсэг</i>	Эрх зүйн мэдээллийн нэгдсэн системд хуулийн төсөлд санал өгөх хугацааг 2026.06.26-ны өдөр гэж заажээ.
60-с доошгүй хоногийн хугацаанд нийтэлж, санал авсан байх <i>ХТТХ-ийн 38.4 дэх хэсэг</i>	Хуулийн төслийг Эрх зүйн мэдээллийн нэгдсэн системд 2026.04.29-ний өдөр нийтэлж, 2026.06.26-ны өдрийг хүртэл санал авахаар тусгасан ⁶ боловч уг хугацаанаас өмнө буюу 2026.05.27-ны өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн. Ийнхүү 28 өдөр санал авсан нь ХТТХ-ийн шаардлагад нийцэхгүй.
Хуулийн төслийг бүрэн нийтлэх <i>ХТТХ-ийн 38.4 дэх хэсэг</i>	Эрх зүйн мэдээллийн нэгдсэн системд хуулийн төслийг дагалдах хуулийн төслүүдийн хамт нийтэлсэн.
Бүрдүүлбэрт хамаарах баримт бичгийг хуулийн төслийн хамт нийтлэх <i>ХТТХ-ийн 38.4 дэх хэсэг 40.1.2, 40.1.3 дахь заалт</i>	Хууль тогтоомжийн бүрдүүлбэрт хамаарах: <ul style="list-style-type: none"> - Үзэл баримтлал, - Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагын тандан судалгаа, эсхүл хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ, - Үр нөлөөний үнэлгээ, - Зардлын тооцоо, - Хуулийн төслийн дэлгэрэнгүй танилцуулга монгол, англи хэлээр, - Хуулийн төслийн товч танилцуулгыг нийтэлсэн.
Олон нийт санал өгөх боломжтой байх <i>ХТТХ-ийн 38.2, 38.4</i>	Иргэд Эрх зүйн мэдээллийн нэгдсэн сангаар дамжуулан хуулийн төсөлд санал өгөхийн тулд ДАН системээр нэвтрэх шаардлагатай. Хуулийн төслийг Эрх зүйн мэдээллийн нэгдсэн санд байршуулснаас хойш 1 сарын хугацаанд 2026.05.22-ны өдрийн байдлаар ердөө 5 санал хүлээн авсан нь нэг талаар ДАН системээр нэвтрэх шаардлага иргэдэд хүндрэлтэй байгааг харуулж байна. Нөгөө талаар хуулийн төсөлд Эрх зүйн мэдээллийн нэгдсэн сангаар дамжуулан санал авах зохицуулалт хэрэгжиж эхлээд удаагүй бөгөөд иргэд энэ талаар мэдээлэл бага байгаатай холбоотой байж болзошгүй.

Дээрхээс дүгнэхэд, Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг өргөн мэдүүлэхээс өмнөх шатанд ХТТХ-д заасан ил тод, нээлттэй байдлын шаардлага зохих ёсоор хэрэгжээгүй байна.

Нээлттэй байдлын шалгуурууд нь хуулийн хэрэгжих боломж, хүлээн зөвшөөрөгдөх байдал, олон нийтийн оролцоог хангах суурь нөхцөл учраас тул хуулийн төслийг өргөн мэдүүлэх, УИХ-аар хэлэлцэх шатанд үүнийг анхаарах нь зүйтэй.

⁵ Эрх зүйн мэдээллийн нэгдсэн сан, “Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл”, нийтэлсэн огноо: 2026 оны 4 сарын 29-ний өдөр.
https://legalinfo.mn/mn/discussiondetail/17436602043482?type=LIS_LAW&page=1

⁶ Эрх зүйн мэдээллийн нэгдсэн сан, Хуулийн төсөлд санал өгөх цэс, <https://legalinfo.mn/mn/discussion?id=1>

ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦООГ ХАНГАХ ЗАРЧМЫН ХЭРЭГЖИЛТ

Хууль тогтоох үйл ажиллагааны чанар, үр нөлөөг нэмэгдүүлэх үндсэн механизм нь хууль тогтоомжийн төслийг олон нийтээр хэлэлцүүлэх явдал юм.⁷ Иймд ХТХ-ийн 4 дүгээр зүйлд олон нийтийн оролцоо нь хууль тогтоох үйл ажиллагаанд баримтлах үндсэн зарчим болохыг заагаад 8 дугаар зүйлийн 8.1.5 дахь хэсэгт “эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх иргэн, хуулийн этгээдийн төлөөлөл, олон нийтээр хууль тогтоомжийн төслийг хэлэлцүүлж, санал авах” шаардлагыг тогтоож, 38 дугаар зүйлд олон нийтийн оролцооны хэлбэрүүдийг тодорхойлжээ. Үүний дагуу хууль санаачлагч хуулийн төсөлд эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх иргэн, хуулийн этгээдийн төлөөллөөс хуульд заасан хэлбэрээр санал авч, хууль тогтоомжийн төслийн бүрдүүлбэрт хавсаргах үүрэгтэй.

Тайлангийн өмнөх хэсэгт цахим хэлбэрээр олон нийтээс санал авсан байдлыг авч үзсэн бол энэ хэсэгт хэлэлцүүлгийн бусад хэлбэр,

түүнд тавигдах нарийвчилсан шаардлагын хэрэгжилтийг дүгнэв. ХТХ-иар уулзалт, хэлэлцүүлгийн хэлбэрээр санал авахад мөрдөх шаардлагыг нарийвчлан тогтоогоогүй боловч эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх талуудыг оновчтой тодорхойлох, боломжит хугацааны өмнө урьдчилан мэдэгдэх, хуулийн төсөл, тухайн бүлэгт үзүүлэх эерэг, сөрөг нөлөөллийг танилцуулах, хэлэлцүүлгийг тэдний онцлог, хэрэгцээнд тохирсон хэлбэрээр зохион байгуулах, саналын товъёг бэлтгэн хуулийн төсөлд хавсаргах зэрэг зүй ёсны нийтлэг шаардлага үйлчилнэ.

Энэ хүрээнд судалгааны багийн зүгээс хуулийн төслийн хэлэлцүүлгийн талаар мэдээлэл авах хүсэлтийг 2026 оны 04 сарын 06-ны өдөр АҮЭБЯ-д гаргасан боловч албан ёсны хариу хүлээн аваагүй. Иймд энэхүү бодлогын шинжилгээг олон нийтэд нээлттэй эх сурвалжийн хүрээнд хийж гүйцэтгэв.

⁷ Р.Оюундэлгэр, Б.Ариунзаяа, “Хууль, тогтоомжийн төслийн ил тод байдал ба олон нийтээр хэлэлцүүлэх шаардлагын хэрэгжилт”, Нээлттэй нийгэм форум, (2025) <https://forum.mn/product/459176>, 10 дахь тал

Хүснэгт 3. Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эрх, ашиг сонирхол нь хөндөгдөж буй этгээд, олон нийтээр хэлэлцүүлсэн байдал

Хэлэлцүүлэгт тавигдах шаардлага	Хэрэгжилт
<p>Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх иргэн, хуулийн этгээдийн төлөөлөөс санал авах</p> <p><i>ХТХ-ийн 38.10 дахь хэсэг</i></p>	<p>АҮЭБЯ-аас Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслөөр дагнасан хэлэлцүүлгийг 2025 болон 2026 оны 2 дугаар сард зарим аймагт зохион байгуулжээ.</p> <p>Ингэхдээ 21 аймгийг бүрэн хамарч хэлэлцүүлэг зохион байгуулсан гэх боловч Увс, Өвөрхангай, Дорноговь, Дундговь, Дорнод аймгаас бусад аймагт зохион байгуулсан хэлэлцүүлгийн талаарх мэдээлэл нээлттэй бус байв.</p> <p>УИХ-ын www.d.parliament.mn цахим хуудаст байршсан хуулийн төслийн бүрдүүлбэрт олон нийтийн хэлэлцүүлгийн саналын товьёг байхгүй тул яг аль аймаг, суманд хэдэн хэлэлцүүлэг хийж, ямар санал авсан, тэдгээрийг хуулийн төсөлд хэрхэн тусгасныг мэдэх боломжгүй байна. Тухайлбал, стратегийн ач холбогдол бүхий 4 орд байрших Өмнөговь аймагт хэлэлцүүлэг явагдсан талаар мэдээлэл алга байна. Дээрх 5 аймагт болсон хэлэлцүүлэгт эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх буюу уул уурхай бүхий сумдын удирдлага, иргэд зэрэг заавал санал авбал зохих талууд оролцсон эсэх нь тодорхойгүй байв.</p> <p>Тухайн аймаг, орон нутгийн ашигт малтмалын хайгуул, ашиглалтын нөхцөл байдлаас шалтгаалан ашиг сонирхол нь хөндөгдөх бүлэг, хөндөгдөж болзошгүй эрх, хууль ёсны ашиг сонирхол нь ялгаатай. Өөрөөр хэлбэл, огт уурхайгүй эсхүл цөөн тооны тусгай зөвшөөрөл бүхий орон нутагтай харьцуулахад уул уурхайн үйл ажиллагаа төвлөрсөн аймаг, сумдын иргэд, олон нийтийн эрх ашигт уг хууль шууд бөгөөд илүү нөлөө үзүүлнэ.</p> <p>Хуулийн төслийн хэлэлцүүлгийн талаарх цахим орчинд нийтлэгдсэн мэдээллийг тоймловол:</p> <p>Улаанбаатар хот: “Арга хэмжээнд Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Г.Дамдинням, тус яам, Ашигт малтмал, газрын тосны газар (АМГТГ)-ын холбогдох албан тушаалтнууд, Монголын уул уурхайн үндэсний ассоциацийн гүйцэтгэх захирал Г.Эрдэнэтуяа, тус ассоциацийн гишүүн компаниуд, уул уурхайн салбарын мэргэжлийн болон төрийн бус байгууллагууд, салбарын мэргэжилтнүүд, иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл зэрэг нийт 170 гаруй хүн оролцлоо.”⁸</p> <p>Орон нутаг: Увс аймагт⁹ 500 гаруй, Дорноговь¹⁰ аймагт 300 гаруй, Өвөрхангай¹¹ аймагт 105 гаруй иргэд, төрийн байгууллагууд, аж ахуйн нэгжүүд болон бичил уурхай эрхлэгчдийн төлөөлөл оролцсон талаарх мэдээ байгаа бол, Дорнод,¹² Дундговь¹³ аймагт зохион байгуулагдсан хэлэлцүүлэгт оролцогчдын тухай мэдээлэл байхгүй байна.</p>

⁸ Ашигт малтмал газрын тосны газар, “Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийн урьдчилсан хэлэлцүүлэг боллоо”, (2026.02.10), <https://mrpam.gov.mn/news/ashigt-maltmalyn-tukhai-khuulid-nemelt-uurchlult-oruulakh-khuuliin-tusliin-uridchilsan-kheleltuuuleg-bolloo>

⁹ “Ашигт малтмалын тухай хуульд 500 гаруй иргэн саналаа өглөө”, (2026.02.13), <https://uvschuud.mn/10408.html>

¹⁰ Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам, “Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийн хэлэлцүүлэг Дорноговь аймагт боллоо”, (2026.02.13), <https://mmhi.gov.mn/2026/02/13/%D0%B0%D1%88%D0%B8%D0%B3%D1%82-%D0%BC%D0%B0%D0%BB%D1%82%D0%BC%D0%B0%D0%BD-%D1%82%D1%83%D1%85%D0%B0%D0%B9-%D1%85%D1%83%D1%83%D0%BB%D1%8C-%D0%B4-%D0%BD%D1%8D%D0%BC%D1%8D/>

¹¹ Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам, “Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийн хэлэлцүүлэг орон нутагт үргэлжилж байна”, (2026.02.13), <https://mmhi.gov.mn/2026/02/13/%D0%B0%D1%88%D0%B8%D0%B3%D1%82-%D0%BC%D0%B0%D0%BB%D1%82%D0%BC%D0%B0%D0%BB%D1%8B%D0%BD-%D1%82%D1%83%D1%85%D0%B0%D0%B9-%D1%85%D1%83%D1%83%D0%BB%D1%8C-%D0%B4-%D0%BD%D1%8D%D0%BC%D1%8D%D0%BB/>

¹² Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам, “Ашигт малтмалын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслийн хэлэлцүүлэг болж байна”, (2026.02.13), <https://mmhi.gov.mn/2026/02/13/%D0%B0%D1%88%D0%B8%D0%B3%D1%82-%D0%BC%D0%B0%D0%BB%D1%82%D0%BC%D0%B0%D0%BB%D1%8B%D0%BD-%D1%82%D1%83%D1%85%D0%B0%D0%B9-%D1%85%D1%83%D1%83%D0%BB%D1%8C-%D0%B4-%D0%BD%D1%8D%D0%BC%D1%8D%D0%BB/>

¹³ Дундговь аймаг Засаг дарын Тамгын газар, “Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийн хэлэлцүүлэг боллоо” (2026.02.13), <https://www.facebook.com/dundgobi7059106/>

Хэлэлцүүлэгт тавигдах шаардлага	Хэрэгжилт
	<p>Дүгнэлт: Хуулийн төслийн үйлчлэлд эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх талуудыг бүрэн тодорхойлж, санал аваагүй буюу уул уурхай бүхий аймгууд, ялангуяа сумдын хэмжээнд хэлэлцүүлэг зохион байгуулагдсан эсэх нь эргэлзээтэй байна.</p>
Хэлэлцүүлгийн талаар мэдээлсэн байдал	<p>Хууль санаачлагчийн зүгээс хуулийн төсөл болон хэлэлцүүлгийн мэдээллийг эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөх талуудын онцлогт тохирсон арга, хэлбэрээр урьдчилан хүргэсэн эсэх нь тодорхой бус байна.</p> <p>Хэлэлцүүлгийн талаар мэдээлсэн суваг болон хугацааг үзвэл</p> <ul style="list-style-type: none"> - АҮЭБЯ-ны цахим хуудаст 2026.02.02-ны өдөр хуулийн төслийн хэлэлцүүлгийн зар нийтлэгдсэн.¹⁴ - АМГТГ-ын цахим хуудаст 2026.02.06-ны өдөр зохион байгуулагдах хуулийн төслийн хэлэлцүүлгийн талаар буюу 2026.02.03-ны өдөр мэдээлж, хуулийн төсөлтэй танилцах QR код хавсаргажээ.¹⁵ - Gogo мэдээллийн сайтад 2026.02.09-ний өдөр АҮЭБЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Б.Дашпүрэвийн “Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам, Газрын тосны газар болон холбогдох байгууллагууд Монгол Улсын хэмжээнд уул уурхайн ассоциацитай хамтран 21 аймагт Ашигт малтмалын тухай хууль болон бусад холбогдох хуулиудын нэмэлт, өөрчлөлтийн талаарх хэлэлцүүлгийг өрнүүлнэ. Иймд газрын тос, ашигт малтмал, хүнд үйлдвэрийн салбарын аж ахуйн нэгжүүд, төрийн байгууллагууд, иргэний нийгмийн байгууллагууд, төрийн захиргааны болон орон нутгийн захиргааны байгууллагууд зэрэг бүх оролцогч талыг эдгээр хуулийн хэлэлцүүлэгт идэвхтэй оролцохыг урьж байна” гэсэн ярилцлага мэдээ нийтлэгдсэн. - АМГТГ-ын цахим хуудаст 2026.02.11-ний өдөр¹⁶ “Ашигт малтмалын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслийн хэлэлцүүлгийг 21 аймагт зохион байгуулна” гэсэн мэдээ нийтлэгдсэн. - АҮЭБЯ-ны цахим хуудаст 2026.02.11-ний өдөр нийтэлсэн зарыг харвал, 3 хоногийн хугацаанд буюу 2 сарын 11-13-ны өдрүүдэд 21 аймагт хуулийн төслийн хэлэлцүүлэг зохион байгуулахаар тус тус мэдээлжээ. <p>Дүгнэлт: Хэлэлцүүлгийг мэдээлсэн хугацаа хэт богино байгаа нь орон нутагт бэлтгэл хангах, оролцогчдод хуулийн төсөлтэй нарийвчлан танилцаж, санал, хүсэлтээ боловсруулах боломж олгоогүй байна.</p>

posts/%D0%B0%D1%88%D0%B8%D0%B3%D1%82-%D0%BC%D0%B0%D0%BB%D1%82%D0%BC%D0%B0%D0%BB%D1%8B%D0%BD-%D1%82%D1%83%D1%85%D0%B0%D0%B9-%D1%85%D1%83%D1%83%D0%BB%D1%8C-%D0%B4-%D0%BD%D1%8D%D0%BC%D1%8D%D0%BB%D1%82-%D3%A9%D3%A9%D1%80%D1%87%D0%BB%D3%A9%D0%BB%D1%82-%D0%BE%D1%80%D1%83%D1%83%D0%BB%D0%B0%D1%85-%D1%85%D1%83%D1%83%D0%BB%D0%B8%D0%B9%D0%BD-%D1%82%D3%A9%D1%81%D0%BB%D0%B8%D0%B9%D0%BD-%D1%85%D1%8D%D0%BB%D1%8D%D0%BB%D1%86%D2%AF%D2%AF%D0%BB%D1%8D/1339639794869205/

¹⁴ Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам, “Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл” олон нийтийн хэлэлцүүлэг, (2026.02.02), <https://mmhi.gov.mn/2026/02/02/%d0%b0%d1%88%d0%b8%d0%b3%d1%82-%d0%bc%d0%b0%d0%bb%d1%82%d0%bc%d0%b0%d0%bb%d1%8b%d0%bd-%d1%82%d1%83%d1%85%d0%b0%d0%b9-%d1%85%d1%83%d1%83%d0%bb%d1%8c%d0%b4-%d0%bd%d1%8d%d0%bc%d1%8d%d0%bb%d1%82-%d3%a9-4/>

¹⁵ Ашигт малтмал газрын тосны газар, “Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл” олон нийтийн хэлэлцүүлэг, (2026.02.03), <https://mrpam.gov.mn/news/ashigt-maltmalyn-tukhai-khuulid-nemelt-uurchlult-oruulakh-tukhai-khuuiliin-tusul-olon-niitiin-kheleltuuleg>

¹⁶ Ашигт малтмал газрын тосны газар, “Ашигт малтмалын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслийн хэлэлцүүлгийг 21 аймагт зохион байгуулна”, (2026.02.11), <https://mrpam.gov.mn/news/ashigt-maltmalyn-tukhai-khuuiliin-nemelt-uurchlultiin-tusliin-kheleltuulgiig-21-aimagt-zokhion-baiguulna>

Хэлэлцүүлэгт тавигдах шаардлага	Хэрэгжилт
Хэлэлцүүлэг зохион байгуулсан хэлбэр	<p>Бүх хуулийн төсөлд тохирсон хэлэлцүүлгийн нэгдсэн арга хэлбэр гэж байхгүй тул тухайн хуулиар зохицуулах харилцааны онцлог, үйлчлэх хүрээнээс хамаарч тохирох хэлбэрийг сонгох нь зүйтэй.¹⁷</p> <p>Хууль тогтоомжийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.6-д олон нийтийн хэлэлцүүлэг явуулах хэлбэрийг бичгээр санал авах, уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулах, санал асуулга явуулах, цахим хэлбэрээр хэлэлцүүлэг явуулах болон бусад гэж заасан. Ашигт малтмалын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөлд уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах болон цахимаар санал авах хэлбэрийг хослуулан ашиглажээ.</p> <p>А. Уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулсан байдал:</p> <p>Дээр дурдсанчлан биечилсэн уулзалт, хэлэлцүүлгийг Улаанбаатар хот болон Дорнод, Дорноговь, Увс, Өвөрхангай, Дундговь аймгуудад зохион байгуулсан байна. Хуулийн төсөлд уулзалт, хэлэлцүүлэг хийж санал авах нь хууль санаачлагчид төслийн үзэл баримтлал, түүний эерэг нөлөөлөл, гарч болох эрсдэл, сөрөг үр дагаврыг нарийвчлан танилцуулах боломжийг олгодог. Түүнчлэн эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх этгээдүүдтэй биечлэн уулзаж, тэдэнд тулгарч буй асуудал, түүний шалтгаан нөхцөл, шийдвэрлэх арга замын талаар бодитой, анхдагч мэдээлэл авахад ач холбогдолтой юм.</p> <p>Харин дээрх хэлэлцүүлгүүдийн агуулга, хөтөлбөр, хууль санаачлагчийн зүгээс хийсэн хуулийн төслийн танилцуулга, оролцогчдын санал, шүүмж хэлэх хугацаа зэрэг хэлэлцүүлгийн чанар, үр нөлөөг үнэлэхэд шаардагдах мэдээлэл байхгүй (тодорхойгүй) байна.</p> <p>Б. Бичгээр буюу цахимаар санал авсан байдал:</p> <p>Практикт тус хэлбэрийг дийлэнхдээ төрийн байгууллага, мэргэжлийн болон судалгааны байгууллагуудаас санал авахад хэрэглэдэг. АҮЭБЯ нь хуулийн төслийг цахим хуудастаа байршуулж, 2026 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн дотор user@mmhi.gov.mn цахим хаягаар санал ирүүлэхийг мэдэгдсэн байна.</p> <p>Дүгнэлт: Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу саналын товъёгийг бэлтгэж, нийтлээгүй тул ийнхүү бичгээр болон цахимаар санал авах хүрээнд хэнээс, хэдэн санал хүлээн авсан, тэдгээрийг хэрхэн тусгасан талаарх мэдээллийг хянах, мэдэх боломжгүй байна.</p>

¹⁷ The CARDS programme, of Community Assistance for Reconstruction, Development and Stabilization, "Law Drafting Manual: A Guide to the Legislative Process in Albania", <https://ial online.org/wp-content/uploads/2018/05/Rep.-Albania.pdf>, p.39.

Хэлэлцүүлэгт тавигдах шаардлага	Хэрэгжилт												
<p>Хэлэлцүүлгийн хугацаа дууссанаас хойш 30 хоногийн дотор хуулийн төсөлд тусгасан, эс тусгасан талаарх саналын товъёгийг тайлбар, үндэслэлийн хамт албан ёсны цахим хуудсандаа болон хууль тогтоомжийн төсөлд санал авах нэгдсэн цахим системд байршуулах</p> <p><i>ХТХ-ийн 38.7 дахь хэсэг</i></p>	<p>В. Орон нутгийн хэлэлцүүлгээс гарсан саналууд (Нээлттэй эх сурвалжийн мэдээлэл)</p> <p>Хэвлэл мэдээлэл болон албан ёсны цахим хуудаснуудад нийтлэгдсэн мэдээллээс түүвэрлэн, орон нутгийн хэлэлцүүлгийн үеэр иргэд, оролцогчдын зүгээс гаргасан гол саналуудыг аймаг тус бүрээр нэгтгэвэл:</p> <table border="1" data-bbox="432 454 1453 1101"> <thead> <tr> <th data-bbox="432 454 624 491">Аймаг</th> <th data-bbox="624 454 1453 491">Хэлэлцүүлгээс гарсан гол саналууд, чиглэл</th> </tr> </thead> <tbody> <tr> <td data-bbox="432 491 624 595">Дорноговь</td> <td data-bbox="624 491 1453 595"> <ul style="list-style-type: none"> - Тусгай зөвшөөрлийн хяналтыг сайжруулах - Малчдын бэлчээр болон газар тариалангийн бүс нутгийг тодорхой болгох </td> </tr> <tr> <td data-bbox="432 595 624 763">Увс</td> <td data-bbox="624 595 1453 763"> <ul style="list-style-type: none"> - Хуулийн заалтуудыг орон нутгийн онцлогт нийцүүлэн, амьдралд ойртуулах - Байгаль орчинд хортой хууль бус олборлолтыг таслан зогсоож, хариуцлагыг чангатгах - Бичил уурхай эрхлэгчдийн эрх зүйн орчныг тодорхой болгох </td> </tr> <tr> <td data-bbox="432 763 624 965">Өвөрхангай</td> <td data-bbox="624 763 1453 965"> <ul style="list-style-type: none"> - Түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олголтыг нэмэгдүүлэх - Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр (АМНАТ)-ийн орон нутагт хуваарилах хувийг өсгөх - Орон нутгийн иргэд болон аж ахуйн нэгжүүдийн эрх, үүргийг тодорхой болгох </td> </tr> <tr> <td data-bbox="432 965 624 1037">Дорнод</td> <td data-bbox="624 965 1453 1037">Оролцогчдын өгсөн саналын талаарх мэдээлэл нээлттэй эх сурвалжид байхгүй.</td> </tr> <tr> <td data-bbox="432 1037 624 1101">Дундговь</td> <td data-bbox="624 1037 1453 1101">Оролцогчдын өгсөн саналын талаарх мэдээлэл нээлттэй эх сурвалжид байхгүй.</td> </tr> </tbody> </table> <p>Г. Саналын товъёг бэлтгэн нийтлэх үүрэг ба хэрэгжилт</p> <p>УИХ-ын цахим зөвлөлдөх систем (d.parliament.mn)-д байршсан хуулийн төслийн бүрдүүлбэрт саналын товъёг байхгүй байна.</p> <p>Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу хууль санаачлагч нь иргэдээс ирүүлсэн саналыг хэрхэн тусгасан, эсвэл ямар үндэслэлээр татгалзсан талаарх тайлбарыг багтаасан "Саналын товъёг"-ийг заавал бэлтгэж, олон нийтэд нээлттэй нийтлэх үүрэгтэй. Энэхүү товъёг байхгүй байгаа тул хэлэлцүүлгийн явцад орон нутгийн иргэдээс гарсан дээрх зарчмын чухал саналуудыг хуулийн төсөлд тусгасан эсэх, тусгаагүй бол ямар тайлбар, үндэслэл гаргасанд эрх зүйн дүгнэлт өгөх боломжгүй байна.</p>	Аймаг	Хэлэлцүүлгээс гарсан гол саналууд, чиглэл	Дорноговь	<ul style="list-style-type: none"> - Тусгай зөвшөөрлийн хяналтыг сайжруулах - Малчдын бэлчээр болон газар тариалангийн бүс нутгийг тодорхой болгох 	Увс	<ul style="list-style-type: none"> - Хуулийн заалтуудыг орон нутгийн онцлогт нийцүүлэн, амьдралд ойртуулах - Байгаль орчинд хортой хууль бус олборлолтыг таслан зогсоож, хариуцлагыг чангатгах - Бичил уурхай эрхлэгчдийн эрх зүйн орчныг тодорхой болгох 	Өвөрхангай	<ul style="list-style-type: none"> - Түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олголтыг нэмэгдүүлэх - Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр (АМНАТ)-ийн орон нутагт хуваарилах хувийг өсгөх - Орон нутгийн иргэд болон аж ахуйн нэгжүүдийн эрх, үүргийг тодорхой болгох 	Дорнод	Оролцогчдын өгсөн саналын талаарх мэдээлэл нээлттэй эх сурвалжид байхгүй.	Дундговь	Оролцогчдын өгсөн саналын талаарх мэдээлэл нээлттэй эх сурвалжид байхгүй.
Аймаг	Хэлэлцүүлгээс гарсан гол саналууд, чиглэл												
Дорноговь	<ul style="list-style-type: none"> - Тусгай зөвшөөрлийн хяналтыг сайжруулах - Малчдын бэлчээр болон газар тариалангийн бүс нутгийг тодорхой болгох 												
Увс	<ul style="list-style-type: none"> - Хуулийн заалтуудыг орон нутгийн онцлогт нийцүүлэн, амьдралд ойртуулах - Байгаль орчинд хортой хууль бус олборлолтыг таслан зогсоож, хариуцлагыг чангатгах - Бичил уурхай эрхлэгчдийн эрх зүйн орчныг тодорхой болгох 												
Өвөрхангай	<ul style="list-style-type: none"> - Түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олголтыг нэмэгдүүлэх - Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр (АМНАТ)-ийн орон нутагт хуваарилах хувийг өсгөх - Орон нутгийн иргэд болон аж ахуйн нэгжүүдийн эрх, үүргийг тодорхой болгох 												
Дорнод	Оролцогчдын өгсөн саналын талаарх мэдээлэл нээлттэй эх сурвалжид байхгүй.												
Дундговь	Оролцогчдын өгсөн саналын талаарх мэдээлэл нээлттэй эх сурвалжид байхгүй.												

Нэгтгэн дүгнэхэд, Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн нөлөөлөлд өртөх талууд, ялангуяа уул уурхай бүхий сумын иргэдийг хэлэлцүүлэгт зохих ёсоор хамруулаагүй байхын зэрэгцээ хэлэлцүүлгийн зар, мэдээллийг тулгаж хүргэснээс сонирхогч талууд хэлэлцүүлэгт

оролцох, хуулийн төсөлтэй танилцан саналаа бэлтгэх боломж хязгаарлагджээ.

Мөн хэлэлцүүлгээс гарсан саналыг хуулийн төсөлд бодитоор тусгасан эсэх мэдээлэл байхгүй байгаа нь олон нийтийн хэлэлцүүлгийн ач холбогдол, үр нөлөөг бууруулж байна.

ДУГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Монгол Улсын Засгийн Газраас 2026 оны 5 сарын 27-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах явцад Хууль тогтоомжийн тухай хуульд заасан нээлттэй, ил тод байдал олон нийтийн оролцоог хангах зарчим, шаардлага зохих ёсоор хэрэгжээгүй байна.

Иймд шинжилгээний хүрээнд дараах дүгнэлтийг боловсрууллаа. Үүнд:

Хуулийн төсөл ил тод, нээлттэй байх зарчмын хэрэгжилт:

1. Хууль санаачлагч өөрийн албан ёсны цахим хуудас болон эрх зүйн мэдээллийн нэгдсэн сангаар дамжуулан олон нийтээс санал авах ажиллагааг богино хугацаанд хэлбэр төдий зохион байгуулсан байна.
2. АҮЭБЯ нь хуулийн төслийг өөрийн цахим хуудаст байршуулахдаа “Мэдээ, мэдээлэл” хэсэгт байршуулснаас холбогдох талууд олж үзэхэд бэрхшээлтэй ба үзэл баримтлал, дэлгэрэнгүй болон товч танилцуулга, холбогдох судалгааны тайланг хамт байршуулаагүй байна.
3. Хуулийн төсөлд туссан АМНАТ-ын зохицуулалт нь хөрөнгө оруулалт, татварын орчинд нөлөөлөх тул ХТтХ-ийн дагуу 60 хоногийн хугацаанд санал авах ёстой боловч уг шаардлагыг хэрэгжүүлээгүй. Тодруулбал, яамны цахим хуудсаар 35 хоног, Эрх зүйн мэдээллийн цахим сангаар 28 хоногийн хугацаанд санал авчээ.
4. АҮЭБЯ-ны цахим хуудсаар санал авахдаа зөвхөн имэйлээр санал авах шаардлага тусгасан нь хөдөө, орон нутгийн иргэдэд хүртээмжтэй хэлбэр бус байна.

Оролцоог хангах зарчмын хэрэгжилт:

5. Хуулийн үйлчлэлд эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх талуудыг оновчтой тодорхойлоогүйгээс уул уурхай бүхий сумдын төлөөлөл, иргэдийг хамруулсан хэлэлцүүлэг зохион байгуулаагүй.
6. Аймгуудад зохион байгуулсан хэлэлцүүлгийн зарлалыг хэлэлцүүлэг болохоос гуравхан хоногийн өмнө зарласан нь холбогдох талууд хуулийн төсөлтэй танилцаж, санал хүсэлтээ бэлтгэж оролцох боломжийг хязгаарласан байна.
7. Нийт 21 аймагт хэлэлцүүлэг зохион байгуулсан гэх боловч Увс, Дорнод, Дорноговь, Дундговь, Өвөрхангай аймгаас бусад аймагт зохион байгуулсан хэлэлцүүлгийн талаарх мэдээ, баримт байхгүй.
8. Хэлэлцүүлэг явагдсан аймгийн төвүүдэд зохион байгуулсан хэлэлцүүлгийн агуулга, хөтөлбөр, зохион байгуулалтын талаарх мэдээлэл байхгүйгээс үр дүнг бүрэн үнэлэх боломжгүй байна.
9. Улаанбаатар хот, дээрх 5 аймагт хэлэлцүүлэг зохион байгуулагдах явцад хуулийн төслийн үзэл баримтлал, дэлгэрэнгүй болон товч танилцуулга, холбогдох тооцоо, судалгааны тайлан нийтлэгдээгүй байсан нь олон нийтийн

зүгээс мэдээлэлд үндэслэн оновчтой, үндэслэлтэй санал боловсруулж өгөхөд хүндрэл тулгарчээ.

10. Саналын товъёг бэлтгэн нийтлээгүйгээс хэлэлцүүлгийн үр дүнг мэдэх боломжгүй байна.

Ийнхүү хуулийн төсөл боловсруулах явцад ил тод байдал, олон нийтийн оролцооны шаардлагыг зохих ёсоор хэрэгжүүлээгүй

нь хуулийн хүлээн зөвшөөрөгдөх байдал, хэрэгжих чадамжид сөргөөр нөлөөлж болзошгүй. Иймд Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд хууль зүйн дүгнэлт өгөх болон төслийг УИХ-аар хэлэлцэхэд дээрх нөхцөл байдлыг анхаарч, Хууль тогтоомжийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах арга хэмжээ авах нь зүйтэй.

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

Хууль тогтоомж

1. Монгол Улсын Үндсэн хууль (1992).
2. Ашигт малтмалын тухай хууль (2006).
3. Хууль тогтоомжийн тухай хууль (2015).
4. Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан аргачлалууд, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=207335>

Дотоод эх сурвалж

5. Р.Оюундэлгэр, Б.Ариунзаяа, “Хууль, тогтоомжийн төслийн ил тод байдал ба олон нийтээр хэлэлцүүлэх шаардлагын хэрэгжилт”, Нээлттэй нийгэм форум, (2025) <https://forum.mn/product/459176>
6. “Тогтолцоо дүн шинжилгээ судалгааны хүрээлэн” НҮТББ, “Хууль, тогтоомжийн төсөл судалгаа, шинжилгээнд үндэслэсэн байх зарчмын хэрэгжилт”, Нээлттэй нийгэм форум, (2025) <https://forum.mn/product/582825>
7. Нээлттэй Нийгэм Форум, “Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд өгсөн санал, шүүмж”, (2026), <https://forum.mn/product/595979>

Гадаад эх сурвалж

8. U.S. Department of State, “2025 Investment Climate Investments: Mongolia”, 2025, <https://www.state.gov/reports/2025-investment-climate-statements/mongolia/>
9. The CARDS programme, of Community Assistance for Reconstruction, Development and Stabilization, “Law Drafting Manual: A Guide to the Legislative Process in Albania”, <https://ialonline.org/wp-content/uploads/2018/05/Rep.-Albania.pdf>

Цахим эх сурвалж

10. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны албан ёсны цахим хуудас, <https://mmhi.gov.mn/>
11. Ашигт малтмал газрын тосны газрын албан ёсны цахим хуудас, <https://mrpam.gov.mn/>
12. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн сан, <https://legalinfo.mn/mn>
13. Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем, <https://user.tender.gov.mn>
14. Шилэн дансны албан ёсны цахим хуудас, <https://shilendans.gov.mn>
15. Gogo.mn мэдээллийн сайт
16. <https://uvschuud.mn> мэдээллийн сайт